



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Биокомбинат" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 42,354,686.87 (дөчин хоёр сая гурван зуун тавин дөрвөн мянга зургаан зуун наян зургаан төгрөг наян долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, "Биокомбинат" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал М.Энх-Амар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000371
6-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 1-2 дугаар сарын 18-ны өдрийн
118 дугаар тогтоолын хавсралт

"БИОКОМБИНАТ" ТӨХХК-ийн ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд он	Тоо ширхэг	Явсан км гүйлт	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	ТӨБЗГ-ын 2024 оны 271 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ	Шинэчлэн тогтоосон үнэ
							(төгрөг)		
1	Тарилга тээврийн машин Зил-130 (путик-дулаалгатай)	03-84 УАК	P3370002	1993/2008	1	549,175	28,076,909.09	3,000,000.00	1,500,000.00
2	Автобус Хьюндай Super-Aerocity	24-72 УБТ	KMJTG18BP BC007283	2010/2010	1	92,570	14,277,777.78	3,500,000.00	1,750,000.00
	Нийт дүн						42,354,686.87 (дөчин хоёр сая гурван зуун тавин дөрвөн мянга зургаан зуун наян зургаан төгрөг наян долоон мөнгө)	6,500,000.00 (зургаан сая таван зуу)	3,250,000.00 (гурван сая хоёр зуун тавин мянга)